

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT РемСостав –хурдан хатуурдаг засварын нэгдэл

Бүтээгдэхүүн нь дотоод болон гадаад ажлын үед бетон, төмөр бетон, тоосгоор хийсэн босоо болон хэвтээ гадаргууг засах, тэгшлэх зориулалттай. Давхаргыг тэгшлэх үеийн зузаан нь 5-аас 50 мм (гүнзгийлсэн газар — 80 мм хүртэл) байна. Ашиглалтын явцад цавууны зуурмагийн температур $+70^{\circ}\text{C}$ хүртэл байна. Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ — 2,5 мм.



Савлагаа — 25 кг, 4 кг

- Шал, хана, таазны хонхор, хотгорыг засах зориулалттай
- Шатны засвар
- Доод давхрын (суурийн) засвар
- Зуурмагийг хэрэглэснээс хойш 3 цагийн дотор гадаргууг ашиглах боломжтой;
- Түвшин тэгшлэх давхаргын зузаан нь 50 мм хүртэл, хонхойлсон нүхэнд 80 мм хүртэл байдаг - янз бүрийн төрлийн ажилд зориулсан универсал шийдэл;
- Ус үл нэвтрүүлэх эсэргүүцэл W8 ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12730.5 стандартын дагуу-чийгт тэсвэртэй байдал;
- Бэхжүүлэгч утастай нь – өндөр хагарал цууралтад тэсвэртэй

Бүтээгдэхүүний зарцуулалт

10 мм зузаантай түрхэх үед $19-20\text{ кг/м}^2$.

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 24 хоногт агаарын температур $+5^{\circ}\text{C}$ хэмээс $+30^{\circ}\text{C}$ хэм хүртэл хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн, суурийн температур, $+10^{\circ}\text{C}$ хэмээс $+30^{\circ}\text{C}$ хэм хүртэл байх нь зохимжтой.

Гадаргууг бэлтгэх

Суурийн гадаргууг тоос, шороо, тос, битум, органик болон эрдэс наалдамхай цавуу, будгийн үлдэгдлээс сайтар цэвэрлэнэ. Гадаргуу дээр ховил хийж, цементэн хальсыг холдуулна. Гадаргууг норгоно.

Зуурмагийн хольц бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа : 1 уут хуурай хольцод 0,11 - 0,16 литр ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийж, нэгэн төрлийн жигд болтол нь 3 минутын турш эргэлтийн хурд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Бэлэн болсон зуурмагийн хольцыг $20\pm 2^{\circ}\text{C}$ температурт хэрэглэх хугацаа 30 минутаас илүүгүй байна.

Ажлын дараалал

Чийгтэй гадаргуу дээр засварын зуурмаг хольцыг түрхэнэ. Хольцыг гар аргаар түрхэж өгнө. Гөлгөр гадаргуутай болгохын тулд зуурмагийн хольцыг өтгөрсний дараа толийллогч индүүгээр индүүднэ. Боловсруулсан гадаргуу нь ажил дууссанаас хойш 3 цагийн дараа ашиглалтад бэлэн болно.

Анхааруулга

Таазны гадаргууг засахдаа хуурай хольцыг аль болох хамгийн бага хэмжээний устай холихыг зөвлөж байна. Булангуудыг дахин сэргээх ажилд хэв оруулагч ашиглахыг зөвлөж байна. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20 ± 2)°C, агаарын харьцангуй чийгшил (60 ± 10)-д үйлчилнэ.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Элс, портландцемент, бэхжүүлэгч утас, өөрчлөгч нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 31357-2007 стандартыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн (Аэфф <370 Бк/кг байх ОХУ-ын "Цацрагийн аюулгүй байдлын стандартууд" НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.25.23–09 нийцсэн.

Техник үзүүлэлтүүд

Хамгийн том дүүргэгч ширхгийн хэмжээ	2,5 мм
Том хэмжээтэй ширхгийн агууламж	5%-иас багагүй
1 кг хольцод хэрэглэх усны хэмжээ	0,11-0,16 л
Хөдөлгөөнт байдал: • бэлтгэсний дараа шүүд • бэлтгэснээс 20 минутын дараа	Пк2 120-150 мм 100 мм багагүй
Зуурмагийн хольцыг барьцалдах хугацаа	30 минутаас наашгүй
Зуурмагийн шахалтад байх бат бэх: • 3 цагийн дараа • 28 хоногийн дараа	10 МПа-аас багагүй 40 МПа-аас багагүй
Бетон суурьтай зуурмагийн наалдах бат бэх чанар 28 хоногийн дараа	1,5 МПа-аас багагүй
Суултын деформац 28 хоногийн дараа	1 1 мм/м ихгүй
Ус нэвтрүүлэхгүй марк	W8
Хүйтэнд тэсвэртэй байдлын зуурмагийн марк	F150
Байгалийн радионуклидын цацраг идэвх	370 Бк/кг ихгүй

25 кг ууттай бүтээгдэхүүний логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013041486

Багц дахь уутны тоо – 48 ширхэг

4 кг ууттай бүтээгдэхүүний логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013045941

Багц дахь уутны тоо – 224 ширхэг